



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 12 дугаар сарын 26

Дугаар А/246

Улаанбаатар хот

Журам, заавар, өргөдлийн маягтын загвар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.13.1 дэх заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэх, бүртгэх журам”-ыг нэгдүгээр, “Тэтгэвэр бодох заавар”-ыг хоёрдугаар, “Өндөр насны тэтгэвэр тогтоолгох өргөдлийн маягтын загвар”-ыг гуравдугаар, “Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгох өргөдлийн маягтын загвар”-ыг дөрөвдүгээр, “Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох өргөдлийн маягтын загвар”-ыг тавдугаар, “Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох маягтын загвар”-ыг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан журам, заавар, маягтыг хэрэгжүүлэх, ажил олгогч, иргэд, даатгуулагчдад сурталчлан таниулахыг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт, мэргэжил, арга зүйгээр ханган ажиллахыг Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газар, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (С.Лхагвадорж)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит, мониторингийн газар (Б.Ганхуяг)-т даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/43, 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн “Журам батлах тухай” А/31 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ, БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТ, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ГАЗРЫН ДАРГА



Ц.ГАНЦЭЦЭГ

1524011416

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 11246
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ БАРИМТ БИЧГИЙН БҮРДЭЛД
ХЯНАЛТ ТАВИХ, ТЭТГЭВРИЙН ХУВИЙН ХЭРЭГ БҮРДҮҮЛЭХ,
БҮРТГЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль (цаашид “хууль” гэх)-д заасан нөхцөлийн дагуу тэтгэвэр тогтооход шаардагдах баримт бичгийг цахим хэлбэрээр болон эх баримт бичиг (цаашид “баримт бичиг” гэх)-ээр бүрдүүлэх, тэтгэвэр тогтоолгох хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт хүлээн авах, тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэх, түүний бүрдлийг нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) хянахад энэхүү журмыг баримтална.

1.2.Нийгмийн даатгалын газар, тасаг, байцаагч (цаашид “нийгмийн даатгалын байгууллага” гэх) тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргасан даатгуулагч, хүн (цаашид “даатгуулагч” гэх)-ээс Засгийн газрын 2023 оны 450 дугаар тогтоолоор баталсан “Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичиг, тэтгэвэр олгох журам”-д заасан баримт бичгийг хүлээн авна.

1.3.Аж ахуйн нэгж, байгууллагын захирал, эзэн, нягтлан бодогч, хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан (цаашид “ажил олгогч” гэх) нь тэтгэвэр тогтооход шаардагдах ажил олгогчоос хамааралтай баримт бичгийг даатгуулагчид саадгүй бүрдүүлж өгөх үүрэг хүлээнэ.

1.4.Ажил олгогч нь ажилтныхаа ажилд авсан, ажлаас чөлөөлсөн, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласан тушаал, шийдвэрийг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд (цаашид “мэдээллийн сан” гэх) тухай бүр оруулж өөрчлөлтийг хийнэ.

1.5.Тэтгэвэр тогтоолгох даатгуулагч 1995 оноос хойшхи хугацааны нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой баримт бичгийг үрэгдүүлсэн тохиолдолд тухайн мэдээлэл нийгмийн даатгалын байгууллагын архив, мэдээллийн санд байгаа бол өргөдлийг нь хүлээн авсан нийгмийн даатгалын байгууллага тухайн даатгуулагчийн хүсэлтийн дагуу холбогдох нийгмийн даатгалын байгууллагаас нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг гаргуулна.

**Хоёр. Өндөр насны тэтгэвэр тогтоолгох
баримт бичгийн үндэслэл болон бүрдлийг хянах**

2.1.Нийгмийн даатгалын байгууллага нь тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан даатгуулагчаас энэ журмын 1.2-т заасан баримт бичгийг хүлээн авч дараах байдлаар хянана. Үүнд:

2.1.1.Даатгуулагч нь тэтгэвэр тогтоолгох өргөдлийг маягтын дагуу бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж, гарын үсгээ зурж баталгаажуулсан байна.

2.1.2.Нийгмийн даатгалын байгууллага нь тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан даатгуулагчийн иргэний, төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдийн төрсний бүртгэлийг Улсын бүртгэлийн системээс, нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан

тухай гэрээ, 1995-2021 он хүртэлх хугацаанд үндсэн болон үндсэн ажлаас гадуур гүйцэтгэсэн ажил үйлчилгээний орлогод шимтгэл ногдуулсан төлөлтийг мэдээллийн сангаас авна.

2.2.Даатгуулагчийн 1995 оноос өмнө ажилласан хугацааг тооцохдоо хөдөлмөрийн дэвтрийг үндэслэнэ. Хөдөлмөрийн дэвтрийн бичилт, баталгаажилтыг доор дурдсанаар хянаж ажилласан хугацааг тооцно. Үүнд:

2.2.1.Ажил олгогч нь даатгуулагчид хөдөлмөрийн болон хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүний хөдөлмөрийн дэвтрийг Сайд нарын Зөвлөлийн 1959 оны 44, 1960 оны 144 дүгээр тогтоол, Сайд нарын Зөвлөл болон МАХН-ын Төв хорооны 140/82 дугаар хамтарсан тогтоол, 1991-1994 онд Хөдөлмөрийн сайдын 1991 оны 219 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дэвтрийг хөтлөх журмын тухай заавар”-ыг үндэслэн нээж олгосон байх бөгөөд уг хөдөлмөрийн дэвтэрт тухайн хүний овог, нэр, төрсөн он, эрхэлж байсан ажил, албан тушаал, ажилд орсон, ажлаас чөлөөлсөн тухай тушаал, шийдвэрийн он, сар, өдөр, дугаарыг засваргүй, үнэн зөв бичиж, гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан байна.

2.2.2.Хэрэв хөдөлмөрийн дэвтэр болон хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүний хөдөлмөрийн дэвтрийн бичилт нь энэ журмын 2.2.1-д зааснаар бичигдээгүй тохиолдолд архивын лавлагаа эсхүл шүүхийн шийдвэрийг үндэслэнэ.

Санамж¹.Даатгуулагчийн 1991 оноос өмнө хөдөө аж ахуйн нэгдэлд малчнаар ажилласан хугацааг нэгдлийн гишүүний хөдөлмөрийн дэвтрийг үндэслэн тооцно. Хэрэв хөдөлмөрийн дэвтэр буруу бичигдсэн, гарын үсэг зурж, тэмдгээр баталгаажуулаагүй, хуулбарласан тохиолдолд тухайн үед мөрдөж байсан БНМАУ-ын Сангийн яам, Статистикийн төв газраас 1968 онд баталсан цалингийн тооцооны бүртгэл буюу нэгдлийн гишүүний цалин хөлсний 70 дугаар дансанд үндэслэн гаргасан хүн өдөртэй авсан цалин хөлсний лавлагаагаар тооцож болно.

2.2.3.Даатгуулагчийн 1991 оны 07 дугаар сарын 01-нээс 1995 он хүртэл хувийн хэвшлийн байгууллагад ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг хөдөлмөрийн дэвтрийг үндэслэн тооцно. Энэ тохиолдолд БНМАУ-ын 1991 оны Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль (хуучин нэрээр)-ийн дагуу тухайн даатгуулагчийн ажиллаж байсан хувийн хэвшлийн байгууллагын цалингийн сангаас 13.5 хувиар тооцож тэтгэврийн санд шимтгэл төлсөн эсэх тухай аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын архивын лавлагааг хавсаргасан байна.

Санамж².Даатгуулагч энэ журмын 2.2.3-т заасан хугацаанд төрийн, төсвийн байгууллага, улсын үйлдвэрийн газар, хувьцаат компанид ажилласан бол нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тухай архивын лавлагаа авахгүй.

2.3.Даатгуулагчийн 1995-2020 оны хооронд ажил хөдөлмөр эрхэлж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг ажил олгогч болон нийгмийн даатгалын байгууллагын баталгаажуулсан нийгмийн даатгалын дэвтэр, 2021 оноос хойш хугацааны шимтгэл төлөлтийг QR код бүхий шимтгэл төлөлтийн лавлагааг үндэслэн тооцно.

Санамж³.Даатгуулагчийн нийгмийн даатгалын дэвтэр /1995-2006 он/-т нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тухайн үед мөрдөж байсан заавар, журмын дагуу нийгмийн даатгалын байцаагч баталгаажуулсан тохиолдолд холбогдох нийгмийн даатгалын газрын архивын лавлагаа авахгүй.

Санамж⁴.Даатгуулагч нийгмийн даатгалын дэвтрээ үрэгдүүлсэн тохиолдолд холбогдох нийгмийн даатгалын газрын архивын лавлагаа, QR код бүхий шимтгэл төлөлтийн лавлагааг үндэслэнэ.

Санамж⁵.Ажил олгогч нь даатгуулагчийн 1995-2020 оны нийгмийн даатгалын дэвтэрт ажилд орсон, ажлаас чөлөөлсөн тухай тушаал, шийдвэрийн он, сар, өдөр, дугаар, эрхэлж байсан ажил, албан тушаалыг үнэн зөв бичиж, гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулсан байна.

Санамж⁶.Даатгуулагчийн хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласан тухай тушаал, шийдвэрийг ажил олгогчийн илгээсэн мэдээлэлтэй тулган шалгана.

2.4.Нийгмийн даатгалын дэвтэрт даатгуулагчийн сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлого /цаашид “цалин хөлс” гэх/, төлсөн шимтгэлийн хэмжээг буруу, зөрүүтэй бичсэн, эсхүл бичээгүй тохиолдолд холбогдох нийгмийн даатгалын газрын архиваас тухайн даатгуулагчийн шимтгэл төлөлтийн тайланг үндэслэн гаргасан архивын лавлагааг үндэслэнэ.

Санамж⁷.Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар хооронд цахимаар эсхүл цаасаар солилцоно.

2.5.Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуульд заасны дагуу 1990-1994 оны нөхөн тооцуулсан, 1995-2000 оны шимтгэл нөхөн төлсөн хугацааг Нийгмийн даатгалын ерөнхий газрын олгосон “Баталгаажилтын хуудас” (Иргэн (даатгуулагч)-ий ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцсон тухай тэмдэглэгээ) /цаашид “Баталгаажилтын хуудас” гэх/-ыг үндэслэн тооцно.

2.5.1.Даатгуулагчид тэтгэвэр тогтоохдоо энэ журмын 2.5-д заасан хугацааны “Баталгаажилтын хуудас”-ны үндэслэлийг хянана.

Санамж⁸.“Баталгаажилтын хуудас”-ыг үрэгдүүлсэн тохиолдолд холбогдох нийгмийн даатгалын газрын архивын лавлагааг үндэслэнэ.

Санамж⁹.Энэ журмын 2.5-д заасан баримт бичгийн үндэслэлийг шалгахдаа тухайн хугацаанд даатгуулагчийн суралцсан, ажил хөдөлмөр эрхэлсэн, тэтгэвэр авч байсан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан, хорих ял эдэлж байсан эсэх хугацаатай давхацсан эсэхийг хянан шалгана.

2.6.Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн дагуу 1995-2019 оны шимтгэл нөхөн төлсөн хугацааг Нийгмийн даатгалын ерөнхий газрын олгосон “Баталгаажилтын хуудас”-ыг үндэслэн тооцно. Энэ тохиолдолд нөхөн төлсөн хугацаа нь энэ журмын “Санамж⁹”-д заасан хугацаатай давхацсан эсэхийг хянан шалгана.

Санамж¹⁰.Даатгуулагч “Баталгаажилтын хуудас”-ыг үрэгдүүлсэн тохиолдолд холбогдох нийгмийн даатгалын газрын архивын лавлагааг үндэслэнэ.

2.7.Сайн дураар даатгуулагчийн төлсөн шимтгэлийн хэмжээг “Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай цахим гэрээ” болон нийгмийн даатгалын байцаагчийн баталгаажуулсан дэвтэр эсхүл QR код бүхий шимтгэл төлөлтийн лавлагаа байгаа эсэхийг хянана.

2.8.Хөнгөлөлттэй болон хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтооход дараах баримт бичгийн үндэслэлийг хянана. Үүнд:

2.8.1.Олон хүүхэд төрүүлсэн болон үрчлэн авч өсгөсөн эхийн нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох, түүнчлэн төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдийн тоогоор шимтгэл төлсөн хугацааг нэмэгдүүлэн тооцох тохиолдолд тухайн эхийн төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдийн төрсний бүртгэлийн мэдээллийг Улсын бүртгэлийн системийн мэдээлэлтэй тулган шалгана.

Санамж¹¹.Хүүхдийн төрсний гэрчилгээ үрэгдсэн эсхүл шинээр авсан бол улсын бүртгэлийн байгууллагын лавлагааг үндэслэнэ.

2.8.2.Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтэрт бичигдсэн хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд хамаарах албан тушаалд томилсон, чөлөөлсөн тушаал, шийдвэрт заасан ажил, мэргэжил, албан тушаал тохирч байгааг хянана.

Энэ тохиолдолд ажил олгогч нь тухайн даатгуулагчийн хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласан хугацааны ажилд томилсон, ажлаас чөлөөлөгдсөн тухай

тушаал, шийдвэрийг мэдээллийн санд оруулаагүй тохиолдолд уг тушаал, шийдвэрийг эхээр нь авах шаардлагатай.

Санамж¹².Шаардлагатай тохиолдолд ажил олгогчоос хөдөлмөрийн нөхцөлийн тодорхойлолт, аж ахуйн нэгж, байгууллагын гэрчилгээ, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хуулбар, даатгуулагчийн албан тушаалын тодорхойлолт, ажлын байрны нөхцөлийн хэмжилт, шинжилгээний дүгнэлт болон хэвийн бус нөхцөлд ажилласныг нотлох бусад баримт бичгийг нэмэлтээр авч болно.

Санамж¹³.Хөдөлмөрийн хэвийн нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох даатгуулагчаас энэ журмын 1.2-т заасан ажлаас чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийг авахгүй.

2.8.3. Сонгодог, мэргэжлийн урлагийн багууллага, төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын албанд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох тохиолдолд холбогдох тушаал, шийдвэр, архивын лавлагааг үндэслэх бөгөөд түүнд бичигдсэн ажил, мэргэжил, албан тушаал нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7-д заасан ажил, мэргэжил, албан тушаалтай тохирсон байна.

2.8.4. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн дарга, гишүүнээр ажилласан нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох тохиолдолд Цэцийн гишүүнээр томилсон, чөлөөлсөн тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолыг үндэслэнэ.

2.9. Малчны нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн үндэслэл шаардлага хангахгүй тохиолдолд холбогдох нийгмийн даатгалын газрын дэргэдэх Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-өөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ. Үүнд:

2.9.1. Даатгуулагчийн Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллого"-ын бүртгэл /цаашид “малын А данс” гэх/ бүртгэл байхгүй, устсан, үрэгдсэн;

2.9.2. Даатгуулагчийн 1995 оноос хойш малчнаар ажилласныг нотлох тушаал, шийдвэр, хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээ, шимтгэл төлснийг нотлох нийгмийн даатгалын дэвтэр устсан, үрэгдсэн зэрэг болно.

2.10. Даатгуулагч 1995 оноос өмнө цэргийн албыг байлдагч, түрүүчээр хаасан бол цэргийн батлах (үнэмлэх), 1995 оноос хойш хугацаат цэргийн алба хаасан бол баталгаажсан нийгмийн даатгалын дэвтрийг үндэслэнэ. Энэ тохиолдолд цэргийн батлах (үнэмлэх) нь засвартай, дутуу бичигдсэн, үрэгдсэн бол цэргийн байгууллагын архивын лавлагааг үндэслэнэ.

Санамж¹⁴.Хугацаат цэргийн алба хаасан хугацаанд нийгмийн даатгалын дэвтэр олгогдоогүй эсхүл үрэгдүүлсэн бол QR бүхий шимтгэл төлөлтийн лавлагааг үндэслэнэ.

Гурав. Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн үндэслэл болон бүрдлийг хянах

3.1. Тэтгэврийн болон Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн энэ журмын 1.2-т заасан баримт бичгийн үндэслэлийг дараах байдлаар хянана. Үүнд:

3.1.1. “Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсан хувь, хугацаа, шалтгааныг тогтоосон акт”-ыг цахимаар ирүүлсэн болон уг актыг Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэмд зааснаар баталгаажуулсан эсэх;

3.1.2. Даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг энэ журмын 2, 9 дэх хэсэгт заасны дагуу тооцсон эсэх;

3.1.3. Даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгох цалин хөлсийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/139 дүгээр тушаалаар баталсан

“Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх журам”-д заасны дагуу тодорхойлсон эсэх;

3.1.4. Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан бол “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт”-ыг хөдөлмөрийн болон эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч баталгаажуулсан эсэх;

3.1.5. Даатгуулагч мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан бол “Мэргэжлээс шалтгаалсан өвчний Эрүүл мэндийн магадлалын салбар зөвлөлийн комисс”-ын гишүүд “Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсан хувь, хугацаа, шалтгааныг тогтоосон акт”-ыг баталгаажуулсан эсэхийг тулган шалгах зэрэг болно.

Дөрөв. Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн үндэслэл болон бүрдлийг хянах

4.1. Тэтгэврийн болон Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтооход энэ журмын 1.2-т заасан баримт бичгийн үндэслэлийг дараах байдлаар хянана. Үүнд:

4.1.1. Даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг энэ журмын 2, 9 дэх хэсэгт заасны дагуу тооцсон эсэх;

4.1.2. Даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгох цалин хөлсийг энэ журмын 3.1.3-т зааснаар тодорхойлсон эсэх;

4.1.3. Тэжээгч нь гэрлэлтийн гэрчилгээгүй тохиолдолд хүүхдийн эцгээрээ овоглож, эцгийн болон эхийн овог нэр, иргэний харъяалал, иргэний бүртгэлийн дугаар бичигдсэн төрсний гэрчилгээтэй эсэх;

Санамж¹⁵. Энэ тохиолдолд Иргэний улсын бүртгэлийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 6 дугаар зүйлийн 6.12.3, 6.12.6-д зааснаар хүүхдийн төрсний гэрчилгээнд хүүхэд эцгээрээ овоглон бүртгэгдсэн бол хамтын амьдралтай байсныг тогтоосон шүүхийн шийдвэрийг нэмэлтээр шаардахгүй, харин хүүхдийн төрсний гэрчилгээнд хүүхэд эцгээрээ овоглоогүй тохиолдолд хүүхдийн эцэг, эхийн хамтын амьдралтай байсныг тогтоосон шүүхийн шийдвэрийг нэмж бүрдүүлэх;

4.1.4. Тэжээгч нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан бол энэ зааврын 3.1.4, 3.1.5-д заасан “Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсан хувь, хугацаа, шалтгааныг тогтоосон акт”-ын баталгаажуулсан эсэхийг хянах зэрэг болно.

Тав. Нэрийн дансны аргаар тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн баримт бичгийн үндэслэл болон бүрдлийг хянах

5.1. 1979 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн даатгуулагч өндөр насны тэтгэврээ нэрийн дансны аргаар тогтоолгох бол тухайн даатгуулагчийн энэ журмын 1.2-т заасан баримт бичгийн үндэслэлийг дараах байдлаар хянана. Үүнд:

5.1.1. Даатгуулагчийн нэрийн дансны гарааны үлдэгдлийг тооцохдоо Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Нэрийн данс нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулах журам”-д зааснаар тооцсон эсэх;

5.1.2. Даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг энэ журмын 2, 9 дэх хэсэгт заасны дагуу тооцсон эсэх;

“Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх журам”-д заасны дагуу тодорхойлсон эсэх;

3.1.4. Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан бол “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт”-ыг хөдөлмөрийн болон эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч баталгаажуулсан эсэх;

3.1.5. Даатгуулагч мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан бол “Мэргэжлээс шалтгаалсан өвчний Эрүүл мэндийн магадлалын салбар зөвлөлийн комисс”-ын гишүүд “Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсан хувь, хугацаа, шалтгааныг тогтоосон акт”-ыг баталгаажуулсан эсэхийг тулган шалгах зэрэг болно.

Дөрөв. Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн үндэслэл болон бүрдлийг хянах

4.1. Тэтгэврийн болон Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтооход энэ журмын 1.2-т заасан баримт бичгийн үндэслэлийг дараах байдлаар хянана. Үүнд:

4.1.1. Даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг энэ журмын 2, 9 дэх хэсэгт заасны дагуу тооцсон эсэх;

4.1.2. Даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгох цалин хөлсийг энэ журмын 3.1.3-т зааснаар тодорхойлсон эсэх;

4.1.3. Тэжээгч нь гэрлэлтийн гэрчилгээгүй тохиолдолд хүүхдийн эцгээрээ овоглож, эцгийн болон эхийн овог нэр, иргэний харъяалал, иргэний бүртгэлийн дугаар бичигдсэн төрсний гэрчилгээтэй эсэх;

Санамж¹⁵. Энэ тохиолдолд Иргэний улсын бүртгэлийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 6 дугаар зүйлийн 6.12.3, 6.12.6-д зааснаар хүүхдийн төрсний гэрчилгээнд хүүхэд эцгээрээ овоглон бүртгэгдсэн бол хамтын амьдралтай байсныг тогтоосон шүүхийн шийдвэрийг нэмэлтээр шаардахгүй, харин хүүхдийн төрсний гэрчилгээнд хүүхэд эцгээрээ овоглоогүй тохиолдолд хүүхдийн эцэг, эхийн хамтын амьдралтай байсныг тогтоосон шүүхийн шийдвэрийг нэмж бүрдүүлэх;

4.1.4. Тэжээгч нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан бол энэ зааврын 3.1.4, 3.1.5-д заасан “Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсан хувь, хугацаа, шалтгааныг тогтоосон акт”-ын баталгаажуулсан эсэхийг хянах зэрэг болно.

Тав. Нэрийн дансны аргаар тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн баримт бичгийн үндэслэл болон бүрдлийг хянах

5.1. 1979 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн даатгуулагч өндөр насны тэтгэврээ нэрийн дансны аргаар тогтоолгох бол тухайн даатгуулагчийн энэ журмын 1.2-т заасан баримт бичгийн үндэслэлийг дараах байдлаар хянана. Үүнд:

5.1.1. Даатгуулагчийн нэрийн дансны гарааны үлдэгдлийг тооцохдоо Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Нэрийн данс нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулах журам”-д зааснаар тооцсон эсэх;

5.1.2. Даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг энэ журмын 2, 9 дэх хэсэгт заасны дагуу тооцсон эсэх;

**Зургаа. Малчны тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн үндэслэл
болон бүрдлийг хянах**

6.1. Даатгуулагчид малчны нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтооход энэ журмын 1.2-т заасан баримт бичгийн үндэслэлийг дараах байдлаар хянана:

6.1.1. Малын “А” дансны бүртгэлийг холбогдох аймаг, нийслэл, сумын архивын лавлагаа, холбогдох баримт бичигтэй тулган шалгаж баталгаажуулах;

6.1.2. Нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан хугацааны үндэслэлийг энэ журмын 2.1-2.10-т зааснаар тооцсон эсэх;

6.1.3. Энэ журмын 2.5-2.6-д заасан “Баталгаажилтын хуудас”-ны үндэслэлийг хянасан эсэх;

6.1.4. Даатгуулагч (иргэн)-ийн тэтгэвэр тогтоолгох цалин хөлсийг энэ журмын 3.1.3-т зааснаар тодорхойлсон эсэх зэрэг болно.

**Долоо. Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох баримт
бичгийн үндэслэл болон бүрдлийг хянах**

7.1. Цэргийн алба хаагчид цэргийн алба хаасны, хөдөлмөрийн чадвар алдсаны болон гэр бүлийн гишүүнд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтооход энэ журмын 1.2-т заасан баримт бичгийн үндэслэлийг дараах байдлаар хянана. Үүнд:

7.1.1. Цэргийн алба хаагчийн цэргийн алба хаасан болон өсгөн тооцсон хугацааг цэргийн архивын лавлагаа болон тухайн цэргийн байгууллагын тодорхойлолттой тулган хянана.

7.1.2. Тагнуулын байгууллагын тухай хуулийн 3.1.8-д заасны дагуу өөр байгууллагад халхавчийн дор ажиллаж байгаа тусгай албаны ажилтны алба хаасан хугацааны лавлагаа, тэтгэвэр тогтоолгох цалин хөлсний тодорхойлолтыг Төрийн болон албаны нууцын тухай хуульд зааснаар хүлээн авч баталгаажуулсан эсэх;

7.1.3. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтоолгох 5 жилийн цалин хөлсний тодорхойлолтыг мэдээллийн сантай тулгаж, хянаж баталгаажуулсан эсэх;

7.1.4. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтоолгох цалин хөлсийг энэ журмын 3.1.3-т зааснаар тодорхойлсон эсэх.

7.2. Даатгуулагчийн 2011 оноос хойш сонсогчоор суралцсан хугацааны тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийг тухайн цэрэг, цагдаагийн сургууль нь харилцагч нийгмийн даатгалын байгууллагын холбогдох даатгалын санд төлсөн тохиолдолд сонсогчоор суралцсан хугацааг нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцно.

Санамж¹⁶. Энэ тохиолдолд цэрэг, цагдаагийн сургуульд сонсогчийн шимтгэл төлсөн тухай нийгмийн даатгалын дэвтэр эсхүл QR код бүхий шимтгэл төлөлтийн лавлагааг үндэслэнэ.

**Найм. Нийгмийн даатгалын байгууллагын архивын лавлагааг
гаргах, солилцох, илгээх, хүлээн авах**

8.1. Нийгмийн даатгалын байгууллагын архивын лавлагаа, мэдээллийг “Нийгмийн даатгалын архивын ажлын заавар”-ын дагуу гарган баталгаажуулж, холбогдох байцаагч, ажилтан болон нийгмийн даатгалын газар хооронд уг зааварт заасан хугацаанд цахимаар эсхүл цаасаар харилцан солилцож хүлээн авч бүрдүүлнэ.

Санамж¹⁷. Нийгмийн даатгалын байгууллагын архив болон мэдээллийн санд байгаа ажил олгогч, даатгуулагчийн шимтгэл төлөлтийн тодорхойлолт болон лавлагааг даатгуулагчийг өөрийг нь явуулахгүйгээр холбогдох аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар хооронд энэ журмын 8.1-д зааснаар цахимаар эсхүл цаасаар гарган ирүүлнэ.

**Ес. Даатгуулагчийн ажилласан болон нийгмийн даатгалын
шимтгэл төлсөн нийт хугацааг тооцох**

9.1. Нийгмийн даатгалын байгууллага нь даатгуулагчийн тэтгэвэр тогтооход баримтлах нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нийт хугацааг тухайн даатгуулагчийн хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэр (цахим дэвтэр), архивын лавлагаа, шүүхийн шийдвэрт заасан ажилд томилсон он, сар, өдрөөс эхлэн чөлөөлөгдсөн он, сар, өдрийн хоорондох ажил, хөдөлмөр эрхлэн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн жил, сар, өдрийг хооронд нь нэмэх замаар тодорхойлно.

9.2. Даатгуулагчийн хөдөө аж ахуйн нэгдэлд малчнаар ажилласан хугацааг тухайн үед мөрдөж байсан БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1960 оны 3 дугаар тогтоолоор баталсан "Хөдөө аж ахуйн нэгдлийн үлгэрчилсэн дүрэм"-д заасны дагуу нэгдлийн гишүүний хөдөлмөрийн дэвтэр болон цалин, хөлсний 70 дугаар дансны лавлагааг үндэслэн доор дурдсанаар тодорхойлно:

9.2.1. 1968 он хүртэл хугацаанд хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүн эмэгтэй малчны нэг жилд ажиллавал зохих хугацааг 110 хоногоор, эрэгтэй малчны нэг жилд ажиллавал зохих хугацааг 150 хоногоор тооцно;

9.2.2. 1968 оны 01 дүгээр сарын 01-нээс 1991 он хүртэл хугацаанд хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүн малчны нэг жилд ажиллавал зохих хугацааг хүйс харгалзахгүйгээр 250 ба түүнээс дээш хоног ажилласан бол тухайн жилд 12 сар буюу нэг жил ажилласнаар тооцно;

9.2.3. Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүн малчин нь дээр дурдсан онуудад жилдээ 110, 150, 250-иас доош хоног ажилласан бол уг хоногийг 30 хоногт хувааж түүний тухайн жилд ажилласан хугацааг сараар тооцно.

9.3. Нийгмийн даатгалын байгууллага нь цэргийн алба хаасны тэтгэвэр тогтооход баримтлах цэргийн жинхэнэ алба хаасан нийт хугацаа (жил, сар)-г цэргийн байгууллагын архивын лавлагаа, холбогдох тушаал, шүүхийн шийдвэрт заасан ажилд томилсон он, сар, өдрөөс эхлэн ажлаас чөлөөлөгдсөн он, сар, өдрийн хоорондох цэргийн жинхэнэ алба хаасан нийт жил, сар, өдрийг хооронд нь нэмэх замаар тодорхойлно.

9.4. Хугацаат цэргийн алба хаагчийн алба хааж эхэлсэн хугацааг цэргийн анги, салбарт хуваарилсан он, сар, өдрөөс, дуусгасан хугацааг бэлтгэлээр халах тухай цэргийн байгууллагын тушаалд заасан он, сар, өдрөөр тус тус тооцно.

9.5. Даатгуулагчийн ажлаас чөлөөлөгдсөн он, сар, өдрөөс эхлэн дараагийн ажилд орсон он, сар, өдрийн хоорондох ажил, хөдөлмөр эрхлээгүй, шимтгэл төлөөгүй хугацааг шимтгэл төлж ажилласан нийт хугацаанд оруулахгүй.

Арав. Тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэх, бүртгэх

10.1. Нийгмийн даатгалын байгууллага нь тэтгэвэр авагчид тэтгэврийн хувийн хэрэг нээж, уг хувийн хэргийг дахин давтагдашгүй дугаараар бүртгэнэ.

Санамж¹⁸. Тэтгэвэр авагчийг нийгмийн даатгалын мэдээллийн санд зөвхөн нэг удаа бүртгэнэ. Жишээ нь: Өндөр насны тэтгэвэр авагч нь асран хамгаалагч болсон тохиолдолд тэжээгчээ алдсаны, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч асран хамгаалагч болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч байж болно. Харин дээр дурдсанаас бусад тохиолдолд нэг тэтгэвэр авагчийг дахин давхардуулан оруулахгүй.

10.2. Тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэргийг Засгийн газрын 2023 оны 450 дугаар тогтоолоор баталсан "Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд

бүрдүүлэх баримт бичиг, тэтгэвэр олгох журам"-д заасан болон тэтгэвэр тогтоолгоход шаардлагатай нэмэлт баримт бичгээр бүрдүүлнэ.

Санамж¹⁹.Тэтгэвэр авагчийн шилжин ирсэн нийгмийн даатгалын байгууллага тэтгэврийн хувийн хэргийн баримт бичгийн бүрдэл, тэтгэврийн тогтоолтыг хянан хүлээн авна.

Санамж²⁰.Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар жилд нэгээс доошгүй удаа тэтгэврийн хувийн хэргийн тооллого хийж, тэтгэврийн хувийн хэргийн бүрдэл, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллана.

10.3.Монгол Улсын Нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээрийн дагуу 2 улсад ажилласан жилийг нэгтгэн тооцуулж тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагч Монгол Улсаас тухайн хэлэлцээр бүхий улс руу шилжсэн тохиолдолд тэтгэврийн хувийн хэргийн хуулбар хувийг тухайн тэтгэвэр авагчид хүлээлгэн өгч, эх хувийг холбогдох нийгмийн даатгалын газрын архивт хадгална.

Арван нэг. Тэтгэвэр тогтооход шаардагдах баримт бичгийг цахимаар хүлээн авах, хянах

11.1.Нийгмийн даатгалын байгууллага нь тэтгэвэр тогтооход шаардагдах баримт бичгийг цахимаар хүлээн авч, шийдвэрлэж болно.

11.2.Даатгуулагч нь тэтгэвэр тогтооход шаардагдах энэ журмын 1.2 дахь хэсэгт заасан баримт бичгийг цахимаар доор дурдсанаар илгээнэ:

11.2.1.Мэдээллийн сангийн "Даатгуулагчийн портал"-д ДАН системээр нэвтрэн орж цахим өргөдлийн маягт бөглөн, иргэний бүртгэлийн дугаар эсхүл регистрийн дугаарыг, өөрийн харьяа нийгмийн даатгалын байгууллага болон тогтоолгох тэтгэврийн төрөл (өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны)-ийг сонгон тэтгэвэр тогтоолгох баримт бичгийг тус бүрээр нь файл үүсгэн бүрэн оруулж илгээнэ.

11.3.Нийгмийн даатгалын байгууллага нь даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгох баримт бичгийг энэ журамд заасны дагуу хянан шалгаж, хуульд заасан нөхцөлийг хангасан тохиолдолд даатгуулагчид өргөдөл хүлээн авсан тухай мэдээллийг харилцаа холбооны боломжит хэлбэрээр илгээнэ.

Санамж²¹.Өргөдөл гаргагч нь тэтгэвэр тогтооход шаардлагатай холбогдох баримт бичгийг файлаар оруулж, цахим өргөдлийн хамт илгээх бөгөөд цахимаар ирүүлсэн баримт бичгээр цахим тэтгэврийн хувийн хэрэг үүсгэж хадгална.

Санамж²².Шаардлагатай тохиололдолд тэтгэвэр авагчаас нэмэлт баримт бичиг авч тэтгэврийн хувийн хэрэгт хадгална.

11.4.Нийгмийн даатгалын байгууллага нь даатгуулагчийн 1995 оноос өмнө хугацааны ажилласан жилийг нотлох хөдөлмөрийн болон хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүний дэвтрийг эх баримт бичгээр нь даатгуулагчаас, бусад холбогдох нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа, тодорхойлолтыг мэдээллийн сангаас тус тус авч, цахим тэтгэврийн хувийн хэрэгтэй хамт давхар цаасан тэтгэврийн хувийн хэргийг нээж хадгална.

Арван хоёр. Бусад зохицуулалт

12.1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаар өндөр насны тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд түүний эхнэр /нөхөр/-ийн өндөр насны тэтгэврийг нэмэгдүүлэхдээ дараах баримт бичгийг хянана. Үүнд:

12.1.1.Гэр бүлийн тухай хуулийн 7.1-д заасан улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн гэрлэлтийн гэрчилгээ;

Санамж²³.Гэрлэлтийн гэрчилгээ үрэгдсэн эсхүл шинээр авсан бол улсын бүртгэлийн байгууллагын лавлагааг үндэслэнэ.

12.1.2.Гэрлэлтийн гэрчилгээний мэдээлэл нь зөрүүтэй тохиолдолд дараах баримт бичгийг үндэслэн тухайн гэр бүлийн гишүүн эхнэр /нөхөр/-ийн хамт амьдарч байсан хугацаа (20 жил)-г тодорхойлно:

а.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөхөөс өмнө буюу 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө гэрлэлтээ бүртгүүлсэн өндөр насны тэтгэвэр авагчийн хувьд гэрлэлтийн гэрчилгээнд гэр бүл болсныг тогтоосон (бичсэн) он, сар, өдрөөр;

б.2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш гэрлэлтээ бүртгүүлсэн өндөр насны тэтгэвэр авагчийн хувьд гэрлэлтийн гэрчилгээнд бүртгэсэн он, сар, өдрөөр;

в.Өндөр насны тэтгэвэр авагчийн гэрлэлтийн гэрчилгээнд гэр бүл болсныг болон бүртгэсэн хугацаа нь 20 жилээс бага боловч төрүүлсэн болон үрчлэн авсан 20 ба түүнээс дээш насны хүүхэдтэй бол хүүхдийнх нь төрсний гэрчилгээг үндэслэн;

г.20 жил ба түүнээс дээш жил хамт амьдарсныг нотлох баримт бичиггүй тохиолдолд шүүхийн шийдвэр зэрэг болно.

12.2.Гадаад улсад удаан хугацаагаар амьдарч байгаа тэтгэвэр авагчийн тэтгэврийг тухайн амьдарч байгаа улс дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газраас авсан тодорхойлолтыг үндэслэн олгоно.

Санамж²⁴.Энэ тохиолдолд тодорхойлолтыг жил бүрийн эхний улиралд багтаан авсан байна.

12.3.Нийгмийн даатгалын байгууллага нь архивын лавлагаа, шүүхийн шийдвэрт дурдсан шалгах шаардлагатай баримт бичгийн үндэслэлийг эрх бүхий байгууллагаар шалгуулах эрхтэй.

Санамж²⁵.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 179 дүгээр зүйл (Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах үндэслэл)-ийг үндэслэн илт үндэслэлгүй шийдвэрийг нотлох баримтын хамт гарган хэрэг хянан шийдвэрлэх ажилагаанд гуравдагч этгээд (нийгмийн даатгалын байгууллага)-ээр оролцуулах хүсэлтийг анх шүүхийн шийдвэр гаргасан шүүхэд хандаж дахин шийдвэрлүүлнэ.

12.3.Нийгмийн даатгалын байгууллага нь тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн төрд байгаа мэдээллийг түүний зөвшөөрлөөр авна.

12.4.Энэ журамд баримтлахаар тусгагдсан холбогдох хуулийн зүйл, заалт, дүрэм, журам, заавар шинэчлэгдсэн, нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд тухайн шинэчлэгдсэн, нэмэлт, өөрчлөлт орсон хуулийн зүйл, заалт, дүрэм, журам, зааврыг баримтална.

Арван гурав. Хариуцлага

13.1. Хуурамч баримт бичиг бүрдүүлэх, худал мэдүүлэх зэргээр тэтгэврийг үндэслэлгүй, эсхүл илүү тогтоолгож авсан бол үндэслэлгүй буюу илүү авсан тэтгэврийг буруутай иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүрэн төлж нийгмийн даатгалын санг хохиролгүй болгож, энэхүү үйлдэл нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хуульд¹ заасан хариуцлага хүлээлгэнэ.


13.2. Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, ёс зүйн зөрчил гаргасан нийгмийн даатгалын байцаагч, ажилтны үйлдэл нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хуульд² заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

¹ Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйл

² Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйл

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн
12/26 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ТЭТГЭВЭР БОДОХ ЗААВАР

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ зааврыг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан тэтгэвэр тогтоолгох нөхцөл хангасан даатгуулагч, хүн /цаашид "даатгуулагч" гэх/-ий тэтгэврийг бодох, тогтоосон тэтгэврийг өөрчлөх, олгоход баримтална.

ХОЁР. Хамрах хүрээ

2.1. Энэ зааварт Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5, 11, 16 дугаар зүйл, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 5, 7 дугаар зүйл, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8, 10, 13 дугаар зүйлд заасан тэтгэвэр тогтоолгох нөхцөлийг хангасан даатгуулагч хамарна.

ГУРАВ. Даатгуулагчийн шимтгэл төлж, ажилласан хугацааг тооцох

3.1. Энэ зааврын 2.1 дэх хэсэгт заасан тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн ажилласан болон нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг энэ тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэх, бүртгэх журам"-ын 1.2-т заасан баримт бичгийг үндэслэн тооцно.

3.2. Тэтгэврийн даатгалын сангаас шинээр тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг дараах хугацаагаар нэмэгдүүлэн тооцно. Үүнд:

3.2.1. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10 (120 сар)-аас доошгүй жил төлсөн эмэгтэй даатгуулагчийн төрүүлсэн болон гурав хүртэл настайд нь үрчлэн авсан зургаан нас хүртэл нь өсгөсөн хүүхэд бүрийн тоогоор нэг жил зургаан сараар тооцсон хугацаа;

3.2.2. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.27 дахь хэсэгт заасны дагуу Дипломат албаны тухай хуулийн дагуу цаг уурын хүнд нөхцөл бүхий улсад ажилласан нэг жилийг нэг жил зургаан сараар тооцон нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн хугацаа;

3.2.3. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.26 дахь хэсэгт заасны дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн цэргийн алба хаасан нэг жилийг нэг жил зургаан сараар нэмэгдүүлэн тооцох бөгөөд цэргийн алба хаасан хугацааны шимтгэлийг цалин хөлснөөс нь, өсгөн тооцсон хугацааны шимтгэлийг шимтгэл төлөх үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа;

3.2.4. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон хугацаанд ажил хөдөлмөр эрхлээгүй тэтгэвэр авагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг 2004 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс хойш тэтгэврийн даатгалын санд төлсөн хугацаа;

3.2.5. Тэтгэвэр тогтоолгосноос хойш тэтгэврийн даатгалын шимтгэл төлж ажилласан хугацаа зэрэг болно.

Санамж¹. Даатгуулагчийн 1995 оноос хойшхи хугацааны зарим сарын нийгмийн даатгалын шимтгэл төлсөн цалин хөлс нь тухайн үед мөрдөж байсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур бол уг хугацааг Засгийн газрын 2023 оны 470 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам”-д заасныг баримтлан шилжүүлэн тооцно.

ДӨРӨВ. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийг бодох

4.1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан нөхцөлийг хангасан даатгуулагчийн өндөр насны тэтгэврийг хэрэв даатгуулагч 1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө төрсөн бол цалинд үндэслэсэн аргаар, 1979 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн, мөн хуулийн 5.1.1, 5.1.2 дахь заалт, 5.2 дахь хэсэгт заасан нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох тохиолдолд зөвхөн нэрийн дансны аргаар, харин 1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 1979 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд төрсөн, түүнчлэн мөн хуулийн 5.1.3, 5.1.4, 5.1.5, 5.1.6, 5.1.7-д заасан нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн хувьд энэ 2 аргаас аль сонгосон аргаар нь бодно.

4.2. Даатгуулагчийн тэтгэвэр бодох дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/139 дүгээр тушаалаар баталсан “Тэтгэвэр тогтоолгох дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох журам”-д зааснаар тодорхойлно.

4.3. Даатгуулагчийн өндөр насны тэтгэврийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 7, 8 дугаар зүйл, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг мөн хуулийн 13 дугаар зүйл, тэжээгчээ алдсаны тэтгэврийг мөн хуулийн 17 дугаар зүйлд заасан аргачлалаар тус тус бодно.

4.3.1. Хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтооход баримтлах шимтгэл төлсөн хугацаанд цэргийн алба хаасан хугацаа орохоор бол түүний авч байсан цалин, хөлснөөс тухайн хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг нэхэмжлэн төлүүлж, нэг жилийг нэг жилээр тооцож, нийт нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцно.

4.3.2. Хоёр тэжээгч нь нас барсан тохиолдолд тэжээгчээ алдсаны тэтгэврийг тэжээгч тус бүрийн сарын цалин хөлсийг итгэлцүүрээр өсгөн, уг цалин хөлсний нийлбэрээс гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тооны хувиар бодно. Энэ тохиолдолд хоёр тэжээгчийн аль олон жил шимтгэл төлсөн хугацаагаар тооцож тэжээгчээ алдсаны тэтгэврийг тогтооно.

4.3.3. Энэ зааврын 4.3.2-т заасан тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоохдоо 2 тэжээгчийн дундаж цалингийн нийлбэр нь тэтгэвэр тогтоолгох үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээнд хүрээгүй тохиолдолд нийлбэр дүнгээс, илүү гарсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээг баримтлан тогтооно.

Санамж². Тэжээгчээ алдсаны тэтгэвэр бодохдоо эхний тэжээгчийн 1995-1999 оны цалин хөлс, хоёр дахь тэжээгчийн 2020-2024 оны цалин хөлсийг сонгосон бол хоёр тэжээгчийн цалин хөлсийг тэтгэвэр тогтоолгохоор сонгосон 5 жилийн сар бүрийн цалин хөлсийг тухайн харгалзах оны итгэлцүүрээр өсгөн тус бүрийн цалин хөлсний дунджийг тодорхойлж Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт заасны дагуу тэтгэвэр тогтоолгох үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээг баримтална.³ (Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооноос 2024 онд тогтоосон сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 660 000 төгрөг байна)

³ Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйл

4.4.Өндөр насны тэтгэврээ нэрийн дансны аргаар бодуулах хүсэлт гаргасан даатгуулагчийн тэтгэврийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу бодно.

4.5.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авч байсан даатгуулагчийн тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан жил тутамд 1 хувиар бодож нэмэгдүүлнэ. Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хугацаандаа тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн тэтгэвэр авагчид хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан 1 хувийн нэмэгдлийг давхардуулан бодохгүй.

4.6.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай болон Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд заасны дагуу хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн бол Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт заасны дагуу дараах аргачлалын дагуу бодно:

4.6.1.Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-иос доошгүй жил төлсөн нөхцөлөөр бүрэн тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчид өндөр насны бүрэн тэтгэврийн эрх үүссэн бол шинээр тогтоогдсон өндөр насны тэтгэврийн хэмжээг өмнө авч байсан хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн хэмжээнээс бууруулахгүй бодно.

Жишээ¹. Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч сарын 958 500 төгрөгийн тэтгэвэр авч байсан, өндөр насны бүрэн тэтгэвэр тогтоолгоход тэтгэвэр нь 750 000 төгрөгөөр тогтоогдсон бол өмнө авч байсан хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр болох 958 500 төгрөгөөр тэтгэврийг тогтоож олгоно.

4.6.2.Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 36 ба түүнээс дээш сар төлсөн нөхцөлөөр бүрэн тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчид өндөр насны тэтгэвэр тогтоох эрх үүссэн бол түүний тэтгэврийн даатгалын шимтгэл төлж ажилласан хугацаа нь өндөр насны хувь тэнцүүлсэн тэтгэврийн нөхцөл хангаж байгаа тохиолдолд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтад заасны дагуу өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтооно.

Санамж³.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэж, Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоосон шийдвэрийн дуусах хугацаанаас хойш эсхүл дуусах хугацаанаас өмнө цуцалсан бол цуцалсан өдрөөс хойш 6 сарын дотор өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан тохиолдолд дээр дурдсан хуульд заасан нөхцөл үүссэн гэж үзэж өндөр насны тэтгэврийг шинээр тогтоож, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн хэмжээнээс тэтгэврийг нь буулгахгүйгээр тогтооно.

4.7.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох тохиолдолд өндөр насны тэтгэврийн хэмжээг өмнө авч байсан хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврээс бууруулахгүй бодно.

Жишээ².Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч сарын 750 000 төгрөгийн тэтгэвэр авч байсан, өндөр насны бүрэн тэтгэвэр тогтоолгоход тэтгэвэр нь 650 000 төгрөгөөр тогтоогдсон бол өмнө авч байсан хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн хэмжээ болох 750 000 төгрөгөөр тэтгэврийг тогтоож олгоно.

4.8.Цэргийн байгууллагад цолтой алба хаасан иргэн цэргийн байгууллагаас чөлөөлөгдсөнөөс хойш хөдөлмөрийн чадвар алдсан эсхүл нас барсан тохиолдолд хөдөлмөрийн чадвар алдсаны болон тэжээгчээ алдсаны тэтгэврийг түүний 1995 оноос хойш цолтой ажилласан хугацааны цалин хөлснөөс Засгийн газрын 2019 оны “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 137 дугаар тогтоолын 3 дахь хэсэгт заасны дагуу тэтгэврийн

болон тэтгэмжийн даатгалын шимтгэлийг уг иргэнийг өндөр насны тэтгэвэр тогтоолгох үед нийгмийн даатгалын байгууллагаас улсын төсвөөс нэхэмжлэн төлүүлж⁴ цэргийн алба хаасан нэг жилийг нэг жилээр тооцож тэтгэврийг бодно.

Өөрөөр хэлбэл цэргийн алба хаасан 1 жилийг 6 сараар нэмэгдүүлэхгүй.

ТАВ. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр бодох

5.1.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8, 10, 13 дугаар зүйлд заасан тэтгэврийг Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 9, 12, 14 дүгээр зүйлд заасан аргачлалаар тус тус бодно.

5.2.Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоох эрх үүсэж, тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан цэргийн алба хаагчийн иргэний байгууллагад ажилласан нэг жилийг цэргийн зургаан сард шилжүүлэн цэргийн алба хаасан хугацааг нэмэгдүүлэн бодно.

Энэ тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа 12 сар (1 жил) хүрээгүй тохиолдолд цэргийн алба хаасан хугацааг нэмэгдүүлэн тооцохгүй.

5.3.Цэргийн алба хаасны хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан цэргийн алба хаагч тэтгэвэр тогтоолгохоос өмнө тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацаагаа энэ зааврын 5.2-т зааснаар нэмэгдүүлэн тооцуулах тохиолдолд цэргийн алба хаасны бүрэн тэтгэвэр тогтоолгох нөхцөлийг хангасан тохиолдолд цэргийн алба хаасны бүрэн тэтгэвэр тогтооно.

5.4.Цэргийн хөдөлмөрийн чадвар алдсаны болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтооход иргэний байгууллагад нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг цэргийн алба хаасан хугацаанд шилжүүлэн тооцохгүй.

5.5.Цэргийн тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох хөдөлмөрийн чадваргүй гишүүний хоёр тэжээгч нь нас барсан тохиолдолд тэтгэврийг нь нас барсан хоёр цэргийн алба хаагчийн итгэлцүүрээр өсгөсөн цалин хөлсний нийлбэрээс бодно. Энэ тохиолдолд энэ зааврын Санамж²-т заасныг баримтална.

5.6.Цэргийн алба хаагчид тэтгэвэр тогтоохдоо цэргийн байгууллагаас гаргасан цалингийн тодорхойлолтод тусгасан цалин хөлсний хэмжээ нь нийгмийн даатгалын мэдээллийн санд байгаа цалин хөлстэй тохирч байгаа тохиолдолд нийгмийн даатгалын байцаагчаар хянуулах, баталгаажуулалт хийлгэхгүйгээр хүлээн авч тэтгэврийг бодно.

ЗУРГАА. Тэтгэврийг өөрчлөн тогтоох

6.1.Энэ зааврын 2.1-д заасан даатгуулагч тэтгэвэр тогтоолгосноос хойш ажил хөдөлмөр эрхэлж албан журмаар даатгуулж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол тэтгэврийн хэмжээг нь анх тэтгэвэр тогтоолгоход баримталсан сарын дундаж цалин хөлснөөс тооцон шимтгэл төлсөн сар тутамд 0.125 хувиар тооцон авч байсан тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлнэ.

6.2.Хуульд заасны дагуу өндөр насны болон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгосон тэтгэвэр авагчийн анх тэтгэвэр тогтоолгоход баримталсан шимтгэл төлсөн хугацааг тэтгэвэр тогтоолгосноос хойш албан журмын даатгалд хамрагдаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацаатай нэгтгэн тооцоход бүрэн тэтгэврийн эрх үүсэхээр бол тэтгэврийг нь бүрэн болгон өөрчлөн тогтооно.

Харин өмнө тогтоогдсон тэтгэврийг тогтооход баримталсан шимтгэл төлсөн хугацааг тэтгэвэр тогтоолгосноос хойш шимтгэл хугацаагаар нэмэгдүүлэхэд нийт

⁴ Засгийн газрын 2019 оны "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 137 дугаар тогтоол

шимтгэл төлсөн хугацаа нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтад заасны дагуу хувь тэнцүүлсэн тэтгэврийн эрх хэвээр байгаа тохиолдолд тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэмэгдүүлэн тооцно.

Энэ тохиолдолд бодогдсон тэтгэвэр нь өмнө авч байсан тэтгэврийн хэмжээнээс нэмэгдээгүй тохиолдолд тэтгэврийг хэвээр нь, тэтгэвэр нь авч байсан тэтгэврээс нэмэгдсэн бол нэмэгдсэн хэмжээгээр олгоно.

6.3.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу цэргийн алба хаасны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгосон тэтгэвэр авагчийн анх тэтгэвэр тогтооход баримталсан цэргийн алба хаасан хугацааг тэтгэвэр тогтоолгосноос хойш ажил хөдөлмөр эрхэлж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацаатай нэгтгэн тооцох замаар тэтгэврийг нь өөрчлөн тогтоохгүй, харин энэ зааврын 6.1-д заасны дагуу шимтгэл төлсөн хугацааны нэмэгдлийг тооцож олгоно.

6.4.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт заасны дагуу даатгуулагчид Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу хоёр тэтгэвэр авах эрх зэрэг үүсэхээр бол шимтгэл төлсөн болон цэргийн алба хаасан хугацааг нэгтгэн тооцож нэг тэтгэвэр тогтооно. Энэ тохиолдолд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш шинээр тэтгэвэр тогтоолгох хүний хүсэлтэд үндэслэн шимтгэл төлсөн болон цэргийн алба хаасан хугацааг нэгтгэн тооцож тэтгэврийн даатгалын сангаас эсхүл цэргийн тэтгэврийн аль өөрт нь таатай тэтгэврийг тогтооно.

Цэргийн алба хаасны тэтгэвэр авагч 10-аас доош жил иргэний байгууллагад шимтгэл төлж ажилласан хугацаагаар цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон хугацаагаа нэмэгдүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасны дагуу өөрчлөн тогтооно.

Энэ тохиолдолд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт заасан тухайн цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн төрсөн онд харгалзах өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас (2024 онд эрэгтэй 61 нас 9 сар, эмэгтэй 56 нас 9 сар)-ны нөхцөлийг хангасан байх шаардлага тавихгүй.

Санамж⁴.2010 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс хойш цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон цэргийн алба хаагчийн иргэний байгууллагад нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан хугацаагаар цэргийн алба хаасан хугацааг нэмэгдүүлэн тооцно.

6.5.Энэ зааврын 2.1-д заасан тэтгэвэр авагчийн тэтгэвэр тогтоолгохоос өмнө ажилласан хугацаа, тэтгэвэр тогтоолгосон цалин хөлс өөрчлөгдсөн, дундаж цалингүйгээр болон 6 эсхүл 7 жилийн дундаж цалингаар тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагч 5 жилийн цалингаар тэтгэврээ өөрчлөн тогтоолгохоор хүсэлт гаргасан, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч байгаа хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоо өөрчлөгдсөн зэрэг шалтгаанаар тэтгэврийг өөрчлөн тогтоох тохиолдолд өөрчлөн бодсон тэтгэврийн хэмжээн дээр тухайн тэтгэврийг анх тогтоолгосон хугацаанаас Засгийн газрын 2023 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 239 дүгээр тогтоол болон түүнээс хойш Засгийн газраас хэрэгжүүлсэн тэтгэврийн нэмэгдлийг тооцож олгоно.

Жишээ³.2010 онд тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчийн тэтгэврийг энэ зааврын 6.6-т зааснаар өөрчлөн тогтоох тохиолдолд 2023 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 239 дүгээр тогтоол болон түүнээс хойш Засгийн газраас хэрэгжүүлсэн тэтгэврийн нэмэгдлийг, харин 2023 оны 12 дугаар сард тогтоолгосон тэтгэвэр авагчийн хувьд 2024 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 120 дугаар тогтоолын нэмэгдлийг нэмж тооцно.

6.7.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан “Өндөр насны тэтгэврийн тусгай зохицуулалт”-ыг зөвхөн тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасан нөхцөлийг хангасан гэр бүлийн хоёр тэтгэвэр авагчийн аль нэг нь нас барсан тохиолдолд нас барсан тэтгэвэр авагчийн тэтгэврийн 20 хувиар тооцсон дүнгээр эхнэр /нөхөр/-ийн өндөр насны тэтгэврийг нэмэгдүүлэн нас барсны дараагийн 2 дахь сараас эхлэн, хэрэв түүнээс хойш хүсэлт гаргасан бол мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасан хугацааг баримтлан олгоно⁵.

ДОЛОО. Тэтгэвэр авагч хүсэлт гаргах, шийдвэрлэх

7.1.Энэ зааврын 2.1-д заасан тэтгэвэр авагч шинээр тэтгэвэр тогтоолгох болон өөрчлөн тогтоолгох хүсэлтээ харъяалах Нийгмийн даатгалын газарт цахимаар эсхүл бичгээр гаргана.

7.2.Нийгмийн даатгалын байгууллага нь тэтгэвэр авагчид шинээр тэтгэвэр тогтоохдоо Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.2 дахь хэсэгт, 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэгт тус тус заасан хугацааг, тогтоосон тэтгэврийг өөрчлөхдөө мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасан хугацааг баримтална.

7.3.Хүсэлт гаргасан даатгуулагчид тэтгэвэр тогтоох, тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөн тогтоох тохиолдол бүрд тэтгэвэр тогтоолтын хуудсыг хэвлэн холбогдох хяналтын байцаагч, хэлтсийн дарга, ахлах нягтлан бодогчоор хянуулж, Газрын даргаар баталгаажуулж хувийн хэрэгт холбогдох баримт бичгийн хамт хадгална.

----oOo---

⁵ Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйл

Нийгмийн даатгалын ерөнхий газрын
даргын 2024 оны 12 дугаар сарын 16-ны
өдрийн 12 дугаар тушаалын гуравдугаар
хавсралт

Маягт ӨНТ-1

ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ ӨРГӨДӨЛ

1. Даатгуулагчийн мэдээлэл:

1. Иргэний бүртгэл /регистр/-ийн дугаар: 2. Ургийн овог:
3. Эцэг /эх/-ийн нэр: 4. Өөрийн нэр:
5. Хүйс: эрэгтэй ☐ эмэгтэй ☐
6. Гэрийн хаяг:
7. Утасны дугаар: 1. 2. 8. Цахим шуудан:

2. Даатгуулагчийн ажилласан болон шимтгэл төлсөн хугацааны мэдээлэл:

Би дараах хугацаанд ажил хөдөлмөр эрхлэн, шимтгэл төлсөн болно.

.....-ээсхүртэл буюу нийт.....сар
.....-ээсхүртэл буюу нийт.....сар
.....-ээсхүртэл буюу нийт.....сар
.....-ээсхүртэл буюу нийт.....сар
Нийт жилсар

3. Тэтгэврийн нөхцөл:

1. Өндөр нас /Бүрэн/ ☐ 2. Хөдөлмөрийн хүнд нөхцөлөөр ☐
3. Өндөр нас /Хувь тэнцүүлсэн/ ☐ 4. Сонгодог, мэргэжлийн урлагийн нөхцөлөөр ☐
5. Олон хүүхэдтэй эхийн нөхцөлөөр ☐ 6. Төмөр замын цэрэгжүүлсэн ☐
7. Газрын доор болон хөдөлмөрийн хамгаалалтын албаны нөхцөлөөр ☐
хортой, халуун нөхцөлөөр

4. Тэтгэвэр бодох арга:

Цалинд үндэслэсэн: ☐ Нэрийн дансны: ☐
Тэтгэвэр тогтоолгох 5 жилийн дундаж цалин хөлс сонгох он, сар:
.....онысараасонысар

5. Хүүхдийн мэдээлэл: /Эмэгтэй даатгуулагчийн хувьд хүүхдийн нэр, иргэний бүртгэл /регистр/-ийн дугаар бичнэ/

.....
.....
.....

6. Тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлсэн баримт бичиг:

1. Хөдөлмөрийн дэвтэрширхэг
2. Нийгмийн даатгалын дэвтэрширхэг
3. Бусад шаардлагатай баримт бичигхуудас

7. Тэтгэвэр авах банкны нэр, дансны дугаар:

Тайлбар: Дээрх мэдээллээс тохирохыг нь ☒ гэж тэмдэглэнэ.

- Өргөдөлд дурдсан өөрийн мэдээллийг үнэн зөв мэдээлсэн болно.
- Төрд байгаа миний мэдээллийг ашиглахыг зөвшөөрч байна.
- Хуурамч баримт бичиг бүрдүүлснээс үүсэх үр дагавар, хуулийн хариуцлагыг би өөрөө хүлээнэ.

Өргөдөл гаргасан:

.....
(Овог, нэр)

/...../
(гарын үсэг)

20 ... он ... сар ... өдөр

Нийгмийн даатгалын ерөнхий газрын
даргын 2024 оны 12 дугаар сарын 28-ны
өдрийн 12 дугаар тушаалын дөрөвдүгээр
хавсралт

Маягт ХЧАТ-2

ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДСАНЫ ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ ӨРГӨДӨЛ

1. Даатгуулагчийн мэдээлэл:

- | | |
|--|------------------------|
| 1. Иргэний бүртгэл /регистр/-ийн дугаар: | 2. Ургийн овог: |
| 3. Эцэг /эх/-ийн нэр: | 4. Өөрийн нэр: |
| 5. Хүйс: эрэгтэй ☐ эмэгтэй ☐ | |
| 6. Гэрийн хаяг: | |
| 7. Утасны дугаар: 1. 2. | 8. Цахим шуудан: |

2. Даатгуулагчийн ажилласан болон шимтгэл төлсөн хугацааны мэдээлэл:

Би дараах хугацаанд ажил хөдөлмөр эрхлэн, шимтгэл төлсөн болно.

.....-ээс	хүртэл буюу нийт	сар
.....-ээс	хүртэл буюу нийт	сар
.....-ээс	хүртэл буюу нийт	сар
.....-ээс	хүртэл буюу нийт	сар
Нийт жил		сар

3. Хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан:

- | | |
|--|--|
| 1. Ердийн өвчин ☐ | 2. Мэргэжлээс шалтгаалсан өвчин ☐ |
| 3. Ахуйн осол ☐ | 4. Үйлдвэрлэлийн осол ☐ |

- | | |
|--|-----------|
| 3.1. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь | хувь |
| 3.2. Хөдөлмөрийн чадвар алдалтын хугацаа | сар (жил) |

4. Тэтгэвэр тогтоолгох 5 жилийн дундаж цалин хөлс сонгох он, сар:

..... оны сараас оны сар

5. Хүүхдийн мэдээлэл: /Эмэгтэй даатгуулагчийн хувьд хүүхдийн нэр, иргэний бүртгэл /регистр/-ийн дугаар бичнэ/

.....
.....
.....

6. Тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлсэн баримт бичиг:

- | | |
|--|--------|
| 1. Хөдөлмөрийн дэвтэр | ширхэг |
| 2. Нийгмийн даатгалын дэвтэр | ширхэг |
| 3. Бусад шаардлагатай баримт бичиг | хуудас |

7. Тэтгэвэр авах банкны нэр, дансны дугаар:

Тайлбар: Дээрх мэдээллээс тохирохыг нь ☒ гэж тэмдэглэнэ.

- Өргөдөлд дурдсан өөрийн мэдээллийг үнэн зөв мэдээлсэн болно.
- Төрд байгаа миний мэдээллийг ашиглахыг зөвшөөрч байна.
- Хуурамч баримт бичиг бүрдүүлснээс үүсэх үр дагавар, хуулийн хариуцлагыг би өөрөө хүлээнэ.

Өргөдөл гаргасан:

.....
(Овог, нэр)

/...../
(гарын үсэг)

Нийгмийн даатгалын ерөнхий газрын
даргын 2024 оны 12 дугаар сарын 26-ны
өдрийн 11 дугаар тушаалын тавдугаар
хавсралт 24/6

Маягт ТАТ-3

ТЭЖЭЭГЧЭЭ АЛДСАНЫ ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ ӨРГӨДӨЛ

1. Тэжээгчийн мэдээлэл:

1. Иргэний бүртгэл /регистр/-ийн дугаар:

3. Эцэг /эх/-ийн нэр:

5. Хүйс: эрэгтэй ☐ эмэгтэй ☐

6. Гэрийн хаяг:

7. Нас барсан шалтгаан: ☐ Ердийн өвчин

☐ Ахуйн осол

☐ Бусад

2. Ургийн овог:

4. Өөрийн нэр:

☐ Үйлдвэрлэлийн осол

☐ Мэргэжлээс шалтгаалсан

☐ өвчин

2. Тэжээгчийн ажилласан болон шимтгэл төлсөн хугацааны мэдээлэл:

Тэжээгч дараах хугацаанд ажил хөдөлмөр эрхлэн, шимтгэл төлсөн болно.

.....-ээсхүртэл буюу нийт.....сар

.....-ээсхүртэл буюу нийт.....сар

.....-ээсхүртэл буюу нийт.....сар

.....-ээсхүртэл буюу нийт.....сар

Нийт жилсар

Тэтгэвэр тогтоолгох 5 жилийн дундаж цалин хөлс сонгох он, сар:

.....онысараасонысар

3. Гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүний мэдээлэл:

1. Гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүний тоо:

2. Гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүний овог, нэр, регистрийн дугаар:

4. Мөнгө авагчийн мэдээлэл:

1. Иргэний бүртгэл /регистр/-ийн дугаар:

3. Эцэг /эх/-ийн нэр:

5. Гэрийн хаяг:

6. Тэжээгчийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнтэй ямар хамааралтай:

Эцэг /Эх/

Хүүхэд

2. Ургийн овог:

4. Өөрийн нэр:

☐ Ах, эгч /дүү/

☐ Асран хамгаалагч

5. Хүүхдийн мэдээлэл: / Тэжээгч эмэгтэй бол хүүхдийн нэр, иргэний бүртгэл /регистр/-ийн дугаар бичнэ/

6. Тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлсэн баримт бичиг:

1. Хөдөлмөрийн дэвтэрширхэг

2. Нийгмийн даатгалын дэвтэрширхэг

3. Бусад шаардлагатай баримт бичигхуудас

7. Тэтгэвэр авах банкны нэр, дансны дугаар:

Тайлбар: Дээрх мэдээллээс тохирохыг нь ☒ гэж тэмдэглэнэ.

• Өргөдөлд дурдсан өөрийн мэдээллийг үнэн зөв мэдээлсэн болно.

• Төрд байгаа миний мэдээллийг ашиглахыг зөвшөөрч байна.

• Хуурамч баримт бичиг бүрдүүлснээс үүсэх үр дагавар, хуулийн хариуцлагыг би өөрөө хүлээнэ.

Өргөдөл гаргасан:

.....

(Овог, нэр)

/...../

(гарын үсэг)

20 ... он ... сар ... өдөр

Нийгмийн даатгалын ерөнхий газрын
даргын 2024 оны 11 дугаар сарын 26 -ны
өдрийн 11 дугаар тушаалын зургаадугаар
хавсралт 246

Маягт ЦАХТ-4-1

ЦЭРГИЙН АЛБА ХААСНЫ ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ ӨРГӨДӨЛ

1.Цэргийн алба хаагчийн мэдээлэл:

- | | |
|---|-----------------------|
| 1.Иргэний бүртгэл /регистр/-ийн дугаар: | 2.Ургийн овог:..... |
| 3.Эцэг /эх/-ийн нэр: | 4.Өөрийн нэр:..... |
| 5.Хүйс: эрэгтэй ☐ эмэгтэй ☐ | |
| 6.Гэрийн хаяг:..... | |
| 7.Утасны дугаар: 1. 2. | 8.Цахим шуудан: |

2.Цэргийн алба хаасан хугацааны мэдээлэл:

Би дараах хугацаанд цэргийн алба хаасан болно.

.....-ээсхүртэл буюу нийт.....сар

.....-ээсхүртэл буюу нийт.....сар

Нийт жилсар

Иргэний байгууллагад ажилласан хугацаа:

.....-ээсхүртэл буюу нийт.....сар

.....-ээсхүртэл буюу нийт.....сар

Нийт жилсар

3.Тэтгэврийн төрөл:

Цэргийн алба хаасны бүрэн: ☐ Цэргийн алба хаасны хувь тэнцүүлсэн: ☐

Тэтгэвэр тогтоолгох 5 жилийн дундаж цалин хөлс сонгох он, сар:

.....онысараасонысар

4. Хүүхдийн мэдээлэл: / Зөвхөн эмэгтэй цэргийн алба хаагч хүүхдийн нэр, иргэний бүртгэл /регистр/-ийн дугаар бичнэ /

.....
.....
.....

5.Тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлсэн баримт бичиг:

- | | |
|---|-------------|
| 1.Холбогдох цэргийн байгууллагын лавлагаа |хуудас |
| 2.Хөдөлмөрийн дэвтэр |ширхэг |
| 3.Нийгмийн даатгалын дэвтэр |ширхэг |
| 4.Бусад шаардлагатай баримт бичиг |хуудас |

6.Тэтгэвэр авах банкны нэр, дансны дугаар:

Тайлбар: Дээрх мэдээллээс тохирохыг нь ☒ гэж тэмдэглэнэ.

- Өргөдөлд дурдсан өөрийн мэдээллийг үнэн зөв мэдээлсэн болно.
- Төрд байгаа миний мэдээллийг ашиглахыг зөвшөөрч байна.
- Хуурамч баримт бичиг бүрдүүлснээс үүсэх үр дагавар, хуулийн хариуцлагыг би өөрөө хүлээнэ.

Өргөдөл гаргасан:

.....

(Овог, нэр)

/...../

(гарын үсэг)

20 ... он ... сар ... өдөр

Нийгмийн даатгалын ерөнхий газрын
даргын 2024 оны 12 дугаар сарын 26-ны
өдрийн 11 дугаар тушаалын зургаадугаар
хавсралт 2Н6

Маягт ЦАХТ-4-2

ЦЭРГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДСАНЫ ТЭТГЭВЭР
ТОГТООЛГОХ ӨРГӨДӨЛ

1.Цэргийн алба хаагчийн мэдээлэл:

- 1.Иргэний бүртгэл /регистр/-ийн дугаар: 2.Ургийн овог:.....
3.Эцэг /эх/-ийн нэр: 4.Өөрийн нэр:.....
5.Хүйс: эрэгтэй ☐ эмэгтэй ☐
6.Гэрийн хаяг:.....
7.Утасны дугаар: 1. 2..... 8.Цахим шуудан:

2.Цэргийн алба хаасан хугацааны мэдээлэл:

Би дараах хугацаанд цэргийн алба хаасан болно.

.....-ээсхүртэл буюу нийт.....сар
.....-ээсхүртэл буюу нийт.....сар
.....-ээсхүртэл буюу нийт.....сар
.....-ээсхүртэл буюу нийт.....сар
Нийт жилсар

3.Хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан:

1. Байлдааны талбар, энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх, террорист ☐
үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох зэрэг шалтгааны улмаас
2. Албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон ослын улмаас ☐
3. Албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдолгүй ердийн өвчний улмаас ☐
3.1.Хөдөлмөрийн чадвар алдалтын хувьхувь
3.2.Хөдөлмөрийн чадвар алдалтын хугацаасар, жил

4.Тэтгэвэр тогтоолгох 5 жилийн дундаж цалин хөлс сонгох он, сар:

.....онысараасонысар

5.Тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлсэн баримт бичиг:

- 1.Цэргийн байгууллагын лавлагаахуудас
2.Бусад шаардлагатай баримт бичигхуудас

6.Тэтгэвэр авах банкны нэр, дансны дугаар:

Тайлбар: Дээрх мэдээллээс тохирохыг нь ☒ гэж тэмдэглэнэ.

- Өргөдөлд дурдсан өөрийн мэдээллийг үнэн зөв мэдээлсэн болно.
- Төрд байгаа миний мэдээллийг ашиглахыг зөвшөөрч байна.
- Хуурамч баримт бичиг бүрдүүлснээс үүсэх үр дагавар, хуулийн хариуцлагыг би өөрөө хүлээнэ.

Өргөдөл гаргасан:

.....
(Овог, нэр)

/...../
(гарын үсэг)

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024
оны 12 дугаар сарын 26 ны өдрийн 1 дугаар
тушаалын зургаадугаар хавсралт 24/6

Маягт ЦАХТ-4-3

ЦЭРГИЙН ТЭЖЭЭГЧЭЭ АЛДСАНЫ ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ ӨРГӨДӨЛ

1. Тэжээгчийн мэдээлэл:

- Иргэний бүртгэл /регистр/-ийн дугаар: 2. Ургийн овог:
- Эцэг /эх/-ийн нэр: 4. Өөрийн нэр:
- Хүйс: эрэгтэй ☐ эмэгтэй ☐
- Гэрийн хаяг:

2. Цэргийн алба хаасан хугацааны мэдээлэл:

Тэжээгч дараах хугацаанд цэргийн алба хаасан болно.

- | | | |
|-----------------|------------------------|-----|
|-ээс | хүртэл буюу нийт | сар |
|-ээс | хүртэл буюу нийт | сар |
|-ээс | хүртэл буюу нийт | сар |
|-ээс | хүртэл буюу нийт | сар |

Нийт жил сар

Тэтгэвэр тогтоолгох 5 жилийн дундаж цалин хөлс сонгох он, сар:

..... оны сараас оны сар

3. Тэжээгчийн нас барсан шалтгаан:

- Байлдааны талбар, энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох зэрэг шалтгааны улмаас ☐
- Албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон ослын улмаас ☐
- Албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдолгүй ердийн өвчний улмаас ☐

4. Гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүний мэдээлэл:

- Гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүний тоо:
- Гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүний овог, нэр, регистрийн дугаар:

5. Мөнгө авагчийн мэдээлэл:

- Иргэний бүртгэл /регистр/-ийн дугаар: 2. Ургийн овог:
- Эцэг /эх/-ийн нэр: 4. Өөрийн нэр:
- Гэрийн хаяг:
- Тэжээгчийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнтэй ямар хамааралтай:
Эцэг /Эх/ ☐ Ах, эгч /дүү/ ☐
Хүүхэд ☐ Асран хамгаалагч ☐

6. Тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлсэн баримт бичиг:

- Цэргийн байгууллагын лавлагаахуудас
- Бусад шаардлагатай баримт бичигхуудас

7. Тэтгэвэр авах банкны нэр, дансны дугаар:

Тайлбар: Дээрх мэдээллээс тохирохыг нь ☒ гэж тэмдэглэнэ.

- Өргөдөлд дурдсан өөрийн мэдээллийг үнэн зөв мэдээлсэн болно.
- Төрд байгаа миний мэдээллийг ашиглахыг зөвшөөрч байна.
- Хуурамч баримт бичиг бүрдүүлснээс үүсэх үр дагавар, хуулийн хариуцлагыг би өөрөө хүлээнэ.

Өргөдөл гаргасан:

.....
(Овог, нэр)

/...../
(гарын үсэг)

20 ... он ... сар ... өдөр